

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12.	Шилэн дансны мэдээлэл	9
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.14.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“БҮС НУТГИЙН АВТО ЗАМ
ХӨГЖҮҮЛЭХ, ЗАСВАР АРЧЛАЛТЫН
ТӨСӨЛ (MON-3679)”-ИЙН ЗАХИРАЛ,
ЗТХЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА С.БАТБОЛД ТАНАА

2020.04.21 № 06/1181
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

- Төслийн зөвлөх болон гүйцэтгэгчид олгосон санхүүжилтийн 51,938,715.0 мянган төгрөгийн дүнг НӨАТ-ын хэрэглэгчийн системд чөлөөлөгдсөн худалдан авалтаар бүртгээгүй, төлбөрийн и-баримтыг худалдан авагч нараас шаардаж, анхан шатны баримтад хавсаргаагүй нь албан татвар суутган төлөгч буюу тус ТХН-ийн харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд нь санхүүгийн болон татварын тайланд тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах боломжийг бүрдүүлсэн.
- Багц 2, Багц 4 ажлын гүйцэтгэгчээр сонгогдсон “China state construction Xinjiang Construction Eng (Group) Co.,Ltd”-ний гүйцэтгэсэн ажлын үр дүн нь зээлийн гэрээн дэх ажлын төлөвлөгөө, олгосон санхүүжилтийн дүнтэй харьцуулахад хангалтгүй, гэрээнд заасан ажлыг хугацаандаа гүйцэтгээгүй.


Эдгээр зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн захирал С.Батболд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн төсвийг эдийн засгийн зохих ангиллын дагуу эрх бүхий байгууллагаар албажуулан баталгаажуулах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Хандивлагч орон, олон улсын санхүүгийн байгууллагаас Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй зээлийн болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр засгийн газрын тусгай сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн захирал нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 03-наас 2020 оны 4 дүгээр сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, "Грант Торнтон аудит" ХХК-ийн ахлах аудитор С.Уянга, туслах аудитор А.Уртнасан нар хэрэгжүүлэв.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 325 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Зорилго:

Төслийн үндсэн зорилго нь Улаанбаатараас-Дархан чиглэлийн одоо байгаа 2 эгнээ нийт 204,11 км авто замыг 4 эгнээ авто зам болгохтой уялдуулан өргөтгөх ажлыг хэрэгжүүлэхэд оршиж байна.

Төслийн хэрэгжилт:

Монгол улсын Засгийн газар болон Азийн Хөгжлийн банк хооронд 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдөр нийт 60 сая ам долларыг 25 жилийн хугацаатай жилийн 1,4 хувийн хүүтэй L-3679-MON зээлийн гэрээг байгуулсан байна.

Улаанбаатар-Дархан чиглэлийн 204,11 км авто замыг шинэчлэлтийн барилгын ажлыг нийт 5 багц болгон хуваан хэрэгжүүлж байна. Үүнд:

Төрөл	Хамрах хүрээ	Км зам	Гүйцэтгэгч компани
Багц 1	Баруун аймаг салах тойрог уулзвараас Хар модот давааны ар хүртэлх	37.26	HEILONGJIANG JINYI ROAD AND BRIDGE CP.,LTD
Багц 2	Хар модот давааны араас Урьхан хүртэлх	45.5	China state construction Xinjiang Construction Eng(Group) Co.,Ltd
Багц 3	Урьханаас Сүмбэрийн салдаг уулзвар хүртэл	45.74	Guizhou highway engineering group Co.,Ltd
Багц 4	Сүмбэрийн уулзвараас Цайдамын хөндий хүртэлх	45.08	China state construction Xinjiang Construction Eng(Group) Co.,Ltd
Багц 5	Цайдамын хөндийгөөс Дарханы тойрог уулзвар хүртэлх	30.53	China Geo Engineering corporation
	Нийт	204.11	

Захиалагч буюу Зам тээврийн хөгжлийн яамнаас 2019 оны 6 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл” олгосны дагуу 2019 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс авто замын барилгын ажлыг эхлүүлсэн байна.

Тайлант хугацаанд төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төслийн нягтлан бодох бүртгэлдээ мөрддөг Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, тайлагнахдаа мөрддөг Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэх үлгэрчилсэн загвар” нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ төслийн нягтлан бодох бүртгэлийн “Project financial system” програм хангамж ашигладаг байна.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүү үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679) нь үйл ажиллагааны зардлаа төлөвлөж, үүний дагуу гадаадын зээлээр санхүүждэгтэй холбоотой юм.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь төсөл нь 2019 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн тул эрсдэл багатай, мэдрэмтгий биш гэж үзсэнтэй холбоотой.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн 2019 оны санхүү үр дүнгийн тайлангийн нийт зардал 461,623.4 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 9,232.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн үйл ажиллагаа 2019 оноос эхэлсэн тул өмнөх оны үзүүлэлтээс гарсан өөрчлөлтийг харуулах боломжгүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	322,189.8	(322,189.8)
Бараа материал	-	51,938,715.0	(51,938,715.0)
Үндсэн хөрөнгө	-	62,005.4	(62,005.4)
Нийт хөрөнгө	-	52,322,910.2	52,322,910.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	-	52,322,910.2	52,322,910.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	52,322,910.2	52,322,910.2

Бараа материалд төслийн гүйцэтгэгч, зөвлөхөд олгосон урьдчилгаа санхүүжилтийн дүнг бүртгэж, тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгөд төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаа тайлант онд эхэлсэнтэй холбоотой худалдан авч бэлтгэсэн Тавилга эд хогшил, компьютер, санхүүгийн программ хангамжийг тайлагнасан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой тайлант онд 52,933,200.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 52,771,864.5 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, төлөвлөгөө 99.7 хувьтай байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 4,433,200.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 48,500,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулах төсөв батлагдаж, 100 хувь Азийн хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 52,459,025.4 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэлээ.

Аудитаар нийт 103,879,422.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэнээс 51,940,707.8 мянган төгрөгийн 3 алдаа залруулж, 51,938,715.0 мянган төгрөгийг 4 зөвлөмж өгсөн. Үүнд:

- Хувь хүнээс тээврийн хэрэгсэл түрээслэснээс суутгасан ХХОАТ 450.0 мянган төгрөгийг цалингийн зардалд бүртгэсэн нь Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар баталсан НББ-ийн дансны заавар журмын зардал хүлээн зөвшөөрөх 3.2 заалттай нийцээгүй, үнэн зөв байдлын батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний НӨАТ 1,542.8 мянган төгрөгийг ажил гүйлгээгээр бүртгэсэн боловч санхүүгийн тайланд бүртгээгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 14.3.Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ заалттай нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Төслийн гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нарт олгосон урьдчилгаа санхүүжилтийн 51,938,715.0 мянган төгрөгийг эргэлтийн бус хөрөнгөд дуусаагүй барилгаар бүртгэсэн нь Сангийн сайдын 2019 оны 282 тоот тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 16.3 дахь заалттай нийцэхгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Дэлхий нийтийг хамраад байгаа COVID-19 вирус цар тахлын хэмжээнд хүрсэнтэй холбоотой төслийн гүйцэтгэгч БНХАУ-ын 4 компанийн удирдлага, ажилчид хилээр нэвтрэх боломжгүй байгаа тул төсөл хугацаандаа хэрэгжих боломжгүй байна.

Дараагийн аудитаар Азийн хөгжлийн банкнаас олгосон зээлийн санхүүжилтийн хэрэгжилт, үр дүнг авч үзнэ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Төслийн шилэн дансны ажлын хэсэг нийт 16 төрлийн мэдээллийг сар, улирал, жилээр нь байршуулан боловч үүнээс 12 төрлийн мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Төсөл нь 2019 онд үйл ажиллагаа эхэлсэн тул өмнөх жилд аудит хийгдээгүй.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй анхаарвал зохих асуудлыг ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт

МУЗГ болон АХБ-ны хооронд байгуулсан зээлийн гэрээг дагалдах төслийг удирдах гарын авлагын 4-р бүлэгт АХБ-наас олгох зээлийн санхүүжилтэнд 3.77 сая долларын холбогдох татвар, гаалийн хураамж багтсан буюу НӨАТ-ыг чөлөөлөөгүй байна. Гэтэл Сангийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 253 тоот тушаалаар “зээлийн хөрөнгөөр дотоодын зах зээлээс худалдан авах бараа, ажил үйлчилгээг НӨАТ-өөс чөлөөлөх” жагсаалтад төслийн 4 гүйцэтгэгч компанийн 35,690.4 мянган долларын худалдан авалтын НӨАТ-ын чөлөөлөлт багтсан байна.

Тайлант онд АХБ-наас төслийн зөвлөх болон гүйцэтгэгчид олгосон 19,329.9 сая долларын урьдчилгаа санхүүжилтэд НӨАТ багтсан боловч, Сангийн сайдын тушаалаар НӨАТ хөнгөлөлтөд хамрагдсан нь гүйцэтгэгч компаниудад 1,757.3 сая долларын давхар орлого олох боломжийг олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 46 дугаар тушаалаар баталсан “ОУ-ын байгууллага, хандивлагч орноос ЗГ-ын шугамаар МУ-д олгож буй хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр дотоодын зах зээлээс худалдан авах бараа, ажил үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 3.1.1. хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламж олгох талаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн хуулбар (Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай заалттай байх) заалтыг зөрчсөн байна.

Мөн MON-3679 тоот зээлийн гэрээнд НӨАТ, гааль, бусад татварын хөнгөлөлтийн талаар тодорхой тусгагдаагүй боловч ЗТХЯ нь төслийн зөвлөх болон гүйцэтгэгч нартай 2019 оны 6 сард байгуулсан 156-161 тоот гэрээнүүдийн 14.1 хэсэгт НӨАТ, гааль, ХХОАТ-ын төлөлтөөс чөлөөлөх заалт оруулсан байна.

3.1.2. Эрсдэл

Зээлийн санхүүжилтийг буруу тооцоолж олгосон байх.

3.1.3. Өгсөн зөвлөмж

АХБ-ны баталсан төслийг удирдах гарын авлага, Сангийн сайдын баталсан 253 тоот тушаал болон ЗТХЯ-ны байгуулсан 156-161 тоот гэрээний 14.1 заалтад тусгасан татварын хөнгөлөлтийн тухай зөрүүтэй байгаа нөхцөлийг дахин нягталж, төслийг удирдах гарын авлагад татварын хөнгөлөлтийн талаарх асуудлыг тодорхой зааж оруулах.

Мөн зээлийн санхүүжилтийн дүнг татвар орсон дүнгээр цаашид тооцож олгох эсэх, эсвэл татварын хөнгөлөлтийн дүнгээр бууруулж олгох эсэхийг АХБ-тай зөвшилцөн шийдвэрлэх.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

1. 2018 оны 06 дугаар сард Азийн хөгжлийн банк болон Монгол улсын Засгийн газар хооронд байгуулсан L-3679 дугаарт зээлийн гэрээний төсөл хэрэгжүүлэх гарын авлагын 3-р бүлгийн хүснэгт-4 (Үүргийн хуваарилалт)-т татварын чөлөөлөлт болон түүнтэй холбоотой бичиг баримтын асуудлыг Монгол улсын Сангийн яам зохион байгуулах үүрэгтэй гэж заасан.
2. 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Азийн хөгжлийн банк, Монгол улсын Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол улсын Сангийн яам хоорондын 3-н талт санамж бичгийн 21-р хэсэгт, төслийн үйл ажиллагаа, барилгын ажил болон зөвлөх үйлчилгээ нь нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), гаалийн татвараас чөлөөлөгдөх болохыг Монгол улсын Сангийн яам баталгаажуулсан гэж заасан. Үүнтэй холбоотойгоор Төсөл хэрэгжүүлэх гарын авлагад өөрчлөлт оруулах шаардлагатай тухай мөн тусгасан.
3. 2019 оны 11 дүгээр 15-ны өдрийн Азийн хөгжлийн банк, Монгол улсын Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол улсын Сангийн яам хоорондын 3-н талт санамж бичгийн 37-р хэсэгт, “ЗТХЯ, СЯ хамтран Зээлийн гэрээний бичиг баримтуудад Татварын чөлөөлөлтийн асуудлаар өөрчлөлт оруулахаар АХБ-нд хүсэлт гаргасан, Азийн хөгжлийн банкны зохих журмуудын дагуу 11-р сарын сүүлчээр шийдэгдэнэ” гэж тусгасан.

Дээрх үндэслэлүүдийн улмаас ЗТХЯ болон гүйцэтгэгч компаниудын хооронд байгуулсан барилгын ажлын гэрээг НӨАТ болон гаалийн татвараас хөнгөлөгдсөн дүнгээр хийсэн. Мөн 3.77 сая ам долларын татварын дүн багтсан ба НӨАТ-с чөлөөлөөгүй байна гэсэн асуудал нь хүчин төгөлдөр бус юм.

3.2. Шилэн дансны мэдээллийн талаар

3.2.1. Илрүүлэлт

ТХН нь шилэн дансны сайтад нийт 16 төрлийн мэдээллийг сар, улирал, жилээр нь байршуулан боловч үүнээс 12 төрлийн мэдээллийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 2 дугаар бүлэг 6 дугаар зүйл “Шилэн дансны мэдээлэл”-д заасан заалтуудыг зөрчсөн байна.

3.2.2. Эрсдэл

Мэдээллийн ил тод байдлыг хангахгүй байх.

3.2.3. Өгсөн зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн дагаж мөрдөж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Худалдан авалтын баримт бүрдүүлэлтийн талаар

3.3.1. Илрүүлэлт

Төслийн зөвлөх болон гүйцэтгэгчид олгосон санхүүжилтийн дүнг НӨАТ-ын хэрэглэгчийн системд чөлөөлөгдсөн худалдан авалтаар бүртгээгүй, төлбөрийн баримтыг худалдан авагч нараас шаардаж, анхан шатны баримтад хавсаргаагүй нь албан татвар суутган төлөгч буюу тус ТХН-ийн харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд нь санхүүгийн болон татварын тайланд тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах боломжийг бүрдүүлсэн байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтыг ТХН хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.3.2. Эрсдэл

Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх.

3.3.3. Өгсөн зөвлөмж

Нэмэгдсэн өртгийн татварын хуулийг дагаж мөрдөж, 2019 оны худалдан авалтын холбогдох баримтыг борлуулагч талаас НӨАТ-ын системд нөхөн бүртгүүлэн холбогдох баримтыг санхүүгийн баримтад хавсаргаж, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлийн 14.1-т заасны дагуу бүх гүйцэтгэгч нар НӨАТ-аас хөнгөлөгдөхөөр заасан байгаа. Сангийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 253 дугаар тушаалаар тус төслийн гүйцэтгэгч нар "дотоодын зах зээлээс худалдан авах бараа материал, ажил үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөх төсөл хэрэгжүүлэгчдийн жагсаалтад орсон. Үүний дагуу баримт бүрдүүлэн Татварын ерөнхий газраас татварын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр тусгайд код авсан учир 2019 оны 08 дугаар сараас эхлэн орлогоо бүртгэх боломжгүй байсан. 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Татварын шинэчилсэн хуулийн дагуу дээрх кодоор 2020 онд орлогоо бүртгэх боломжтой. Тухайн үед е-баримтыг нөхөж бүрдүүлэн авна.

3.4. Төслийн гүйцэтгэл, хэрэгжилтийн талаар

3.4.1. Илрүүлэлт

Төслийг хэрэгжүүлэгчийн зүгээс гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл явц удсантай холбогдуулан 2019 онд төлөвлөсөн үйл ажиллагаагаа хангалттай хэрэгжүүлээгүй ба 2019 оны 12 сарын 31-ээрх ажлын гүйцэтгэл болон санхүүжилтийн явц дараах байдалтай байна.

/ам.доллар/

Д/д	Гүйцэтгэгч компаниуд	Ажлын Гүйцэтгэл			Санхүүжилтийн гүйцэтгэл	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэсэн	Хоцрогдол	Хувь	Дүн
Багц 1	HEILONGJIANG JINYI ROAD AND BRIDGE CP.,LTD	91.53%	45.74%	-45.79%	29.54%	3,859,299.11
Багц 2	China state construction Xinjiang Construction Eng(Group)Co.,Ltd	85.10%	9.32%	-75.78%	20.00%	2,755,548.78
Багц 3	Guizhou highway engineering group co.,ltd	93.47%	38.00%	-55.47%	37.99%	5,505,681.49
Багц 4	China state construction Xinjiang Construction Eng(Group)Co.,Ltd	88.88%	8.42%	-80.46%	20.00%	2,342,150.12
Багц 5	China Geo Engineering corporation	90.56%	24.04%	-66.52%	36.63%	3,602,149.58
					28.73%	18,064,829.08

Дээрх хүснэгтэд харуулсан ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь төслийн зээлийн гэрээний хавсралт болох төсөл хэрэгжүүлэх гарын авлагын Төсөл хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд нийцэхгүй байна.

Ялангуяа Багц 2, Багц 4 ажил дээр “China state construction Xinjiang Construction Eng (Group) Co.,Ltd” компани шалгарсан боловч ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт нилээд хоцрогдолтой байгаа нь Зам, тээврийн хөгжлийн яамнаас замын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа компанийн чадавхи, ажлын туршлага зэрэг шалгуур үзүүлэлтийг хэрхэн үнэлж, шалгаруулалт нь үнэн зөв, бодитой хийгдсэн эсэх нь эргэлзээтэй байна.

3.4.2. Эрсдэл

Төсөл хугацаандаа хэрэгжих боломжгүй байгаа учир багц-2, багц-4 ажлыг гүйцэтгэгчид олгосон 2.8 сая долларын илүү төлөлтөөр алдагдал хүлээх эрсдэлтэй байна.

3.4.3. Өгсөн зөвлөмж

Замын ажлын гүйцэтгэгч нарын сонгохдоо шалгаруулалт хууль, журмын дагуу хийгдсэн эсэхийг шалгах, цаашид тухайн гүйцэтгэгч компаниуд төслийн гүйцэтгэлийг хангаж ажиллаж чадах эсэх, үргэлжлүүлэн санхүүжилтийг олгох эсэх талаар МУЗГ-ыг төлөөлөн хэрэгжүүлэгч байгууллага Сангийн яам, Зам тээврийн хөгжлийн яам, зээлдэгч АХБ-тай харилцан зөвшилцөж шийдвэрлэх.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Барилгын ажлын явц нь батлагдсан график төлөвлөгөөнөөс ихээхэн хоцорсон. Шалтгаан нь тухайн жилийн цаг агаарын байдал /бороо, ус ихтэй/ нөлөөлсөн. Барилгын ажлыг эрчимжүүлэх талаар захиалагчаас удаа дараа анхааруулж, заавар зөвлөмж өгсөн боловч арга хэмжээ авч ажиллаагүй. Захиалагч нь тус гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх гэрээг цуцлах саналыг Азийн хөгжлийн банканд хүргүүлсэн боловч зөвшөөрөөгүй. 2019 оны 12 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд гүйцэтгэгчийн гэрээ дүгнэх хурлыг хийсэн боловч хариуцлага хүлээж, шийдвэр гаргах албаны ажилтнууд ирээгүй учир хурал хойшлогдсон.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

СТ-1А

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	52,260,904,825.47
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	322,189,812.61
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	322,189,812.61
31210	Төгрөг	-	59,428,207.14
31211	Төрийн сангийн харилцах	-	59,428,207.14
3122	Гадаад валют	-	262,761,605.47
31223	Арилжааны банк дахь харилцах	-	262,761,605.47
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	51,938,715,012.86
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	-	51,938,715,012.86
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	62,005,373.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	62,005,373.50
392	Биет хөрөнгө	-	53,380,373.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		37,388,280.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(6,231,380.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		23,393,130.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(1,169,656.50)
393	Биет бус хөрөнгө	-	8,625,000.00
39301	Програм хангамж		9,000,000.00
39302	Хасагдуулга		(375,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	-	52,322,910,198.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	52,322,910,198.97
51	Засгийн газрын хувь оролцоо	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	-	52,322,910,198.97
51220	Тайлант үеийн үр дүн	-	52,322,910,198.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	52,322,910,198.97

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	52,775,183,003.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	52,775,183,003.53
120	Нийтлэг татварын бус орлого	-	3,318,466.65
120002	Хүүгийн орлого	-	3,318,466.65
122	Тусламжийн орлого	-	52,771,864,536.88
122002	Зээлийн санхүүжилт /гадаад/	-	52,771,864,536.88
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	461,623,467.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	458,305,001.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	458,305,001.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	287,998,266.09
210101	Үндсэн цалин	-	287,998,266.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	36,119,783.31
210201	Тэтгэврийн даатгал	-	36,119,783.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	29,092,000.00
210304	Байрны түрээс	-	29,092,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	66,640,519.97
210401	Бичиг хэрэг	-	11,207,865.00
210402	Тээвэр, шатахуун	-	45,783,012.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	6,797,437.97
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	-	2,852,205.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,910,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын зардал	-	1,910,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	14,925,000.00
210702	Дотоод албан томилолт	-	14,925,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	4,093,495.19
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,923,636.36
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	169,858.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	17,525,936.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,517,900.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,232,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	7,776,036.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,318,466.65
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,318,466.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг/ үндсэн данснаас	-	3,318,466.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-	52,313,559,535.82
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	9,350,663.15
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	9,350,663.15
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	9,350,663.15
5	НИЙТ ҮР ДҮН	-	52,322,910,198.97

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	52,775,183,003.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	52,775,183,003.53
120	Нийтлэг татварын бус орлого	-	52,775,183,003.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	3,318,466.65
120002	Хүүгийн орлого	-	3,318,466.65
122	Тусламжийн орлого	-	52,771,864,536.88
122002	Зээлийн санхүүжилт /гадаад/	-	52,771,864,536.88
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	453,847,431.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	453,847,431.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	450,528,964.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	287,998,266.09
210101	Үндсэн цалин	-	287,998,266.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	36,119,783.31
210201	Тэтгэврийн даатгал	-	36,119,783.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	29,092,000.00
210304	Байрны түрээс	-	29,092,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	66,640,519.97
210401	Бичиг хэрэг	-	11,207,865.00
210402	Тээвэр, шатахуун	-	45,783,012.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	6,797,437.97
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	-	2,852,205.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,910,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын зардал	-	1,910,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	14,925,000.00
210702	Дотоод албан томилолт	-	14,925,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	4,093,495.19
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,923,636.36
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	169,858.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,749,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,517,900.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	4,232,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,318,466.65
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,318,466.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,318,466.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	52,321,335,572.32

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679) ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	52,008,496,422.86
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	52,008,496,422.86
2200	Дотоод эх үүсвэрээр	-	52,008,496,422.86
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	52,008,496,422.86
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(52,008,496,422.86)
7	САНХҮҮГИЙН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	9,350,663.15
14	Бусад эх үүсвэр	-	9,350,663.15
145001	Гадаад валютын ханшийн зөрүү	-	9,350,663.15
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	9,350,663.15
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	322,189,812.61
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	322,189,812.61

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-
19	Тайлант үеийн үр дүн	52,322,910,198.97	52,322,910,198.97
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,322,910,198.97	52,322,910,198.97

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны		
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	52,933,200,000.00	52,459,025,387.42	(474 174 612,58)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ	4,433,200,000.00	3,964,531,908.05	(468,668,091.95)
Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,433,200,000.00	3,964,531,908.05	(468,668,091.95)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,500,000,000.00	48,494,493,479.37	(5,506,520.63)
Барилга байгууламж	48,500,000,000.00	48,494,493,479.37	(5,506,520.63)
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	52,933,200,000.00	52,771,864,536.88	(161,335,463.12)
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	52,933,200,000.00	52,771,864,536.88	(161,335,463.12)
Төсвийн тохируулга		9,350,663.15	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		322,189,812.61	

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/742/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл (MON-3679)			мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мян.төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Төслийг удирдах гарын авлагад НӨАТ-ийн хөнгөлөлтийн талаар тодорхой заалт, холбогдох өөрчлөлт ороогүй байхад гүйцэтгэгч нарт НӨАТ-ын хөнгөлөлт үзүүлсэн.	-	Зөвлөмж өгч, дүгнэлт хязгаарласан	Төслийн захирал, зохицуулагч	С.Батболд Ц.Түмэнбаяр
2	Шилэн дансны мэдээллийг хугацаанаас нь хоцроож байршуулсан.	-	Зөвлөмж өгсөн	Санхүүгийн мэргэжилтэн	Д.Мөнхцэцэг
3	Зөвлөх, гүйцэтгэгч нарт олгосон санхүүжилтийн дүнг НӨТ-ын системд бүртгээгүй.	51,938,715.0	Зөвлөмж өгсөн	Санхүүгийн мэргэжилтэн	Д.Мөнхцэцэг
4	Төслийн гүйцэтгэл гэрээн дэх төлөвлөгөөний дагуу хийгдээгүй, хангалтгүй байна.		Зөвлөмж өгч, дүгнэлт хязгаарласан	Төслийн захирал, зохицуулагч	С.Батболд Ц.Түмэнбаяр
	Нийт	51,938,715.0			